

“ЭРҮҮЛ МЭНД, НИЙГМИЙН ДААТГАЛЫН САЛБАР 100 ХОНОГТ”

Монгол улсын Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Эрүүл мэнд, нийгмийн даатгалын ерөнхий газар нь Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд бодлого үйл ажиллагаагаа чиглүүлэн Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, хамрагдалтыг нэмэгдүүлэх, нийгмийн даатгалын сангийн орлогыг бүрдүүлж, зарлага санхүүжилтийг цаг хугацаанд нь гүйцэтгэх, нийгмийн даатгалын үйлчилгээг даатгуулагч(иргэд)-д шуурхай үзүүлэх, үйлчилгээнд дэвшилтэт хэлбэр нэвтрүүлэх, тооцоолол судалгаа хийх болон бусад чиг үүргийг амжилттай хэрэгжүүлж, хүн амын нийгмийн баталгааг ханган ажиллаж байна.



НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ОРЛОГЫН

ТӨЛӨВЛӨГӨӨГ 101.6

ХУВИАР ДАВУУЛАН


БИЕЛҮҮЛЭВ

Нийгмийн даатгалын санд

2016 оны 09 дүгээр сарын 30-ны байдлаар 882,1 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлж, орлогын төлөвлөгөөг 101.6 хувиар давуулан биелүүлжээ.



Нийгмийн даатгалын сангийн зарлага /Тэрбум төгрөгөөр/



Мөн хугацаанд нийгмийн даатгалын үйлчилгээг давхардсан тоогоор 4.3 сая даатгуулагчид үзүүлсэн бөгөөд зарлагын санхүүжилтэд 1236.0 тэрбум төгрөгийг зарцуулсан байна.

ЭРҮҮЛ МЭНД, НИЙГМИЙН ДААТГАЛЫН БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААГ СУРТАЛЧЛАХ НЭГДСЭН ӨДӨРЛӨГИЙГ УЛСЫН ХЭМЖЭЭНД ЗОХИОН БАЙГУУЛЛАА


“Засгийн газар 100 хоног” арга хэмжээний хүрээнд Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын бодлого шийдвэр, иргэд, даатгуулагч, ажил олгогчдод Нийгмийн даатгалын болон Эрүүл мэндийн даатгалын тухай хууль тогтоомжийг сурталчилах өдөрлөгийг улс орон даяар 2016 оны 10 дугаар сарын 10-12-ны өдрүүдэд зохион байгууллаа.



Өдөрлөгт 55,0 мянган иргэн хамрагдсанаас 36,3 мянган иргэнд Нийгмийн даатгалын болон Эрүүл мэндийн даатгалын тухай хууль тогтоомжийг сурталчилж, мэдээлэл зөвлөгөө өгч ажиллажээ.

Өдөрлөгөөр 12584 иргэн нийгмийн даатгалд хамрагдаж нийгмийн даатгалын санд нийт 624,6 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна. Тодруулбал 7421 иргэн эрүүл мэндийн даатгалд хамрагдаж 147,5 сая төгрөгийг эрүүл мэндийн даатгалын санд төвлөрүүлсэн бол 5163 иргэн нийгмийн даатгалын сайн дурын даатгалд хамрагдаж 477.1 сая төгрөг төвлөрүүлжээ. Мөн Эрүүл мэндийн сангаас 8856 хүнд 96,7 сая төгрөгийн эмийн үнийн хөнгөлөлт үзүүлж Хаан банкны “Ухаалаг банк” үйлчилгээнд газар дээр нь холбон шимтгэлээ цахимаар төлөх боломжийг бүрдүүлэв. Дээрх өдөрлөгийн үеэр нийгмийн даатгалын шимтгэлийн хуримтлагдсан өр авлагаас 317,4 сая төгрөгийн авлагыг барагдуулжээ.

САЙН ДУРААР ДААТГУУЛАГЧИЙН ГЭРЭЭНД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛЖ ДААТГУУЛАГЧИД ТААТАЙ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ НӨХЦЛИЙГ БҮРДҮҮЛЭВ



Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын А/166 дугаар тушаалаар нийгмийн даатгалын сайн дурын даатгалын гэрээнд нэмэлт, өөрчлөлт орууллаа. Даатгуулагчийн тухайн сарын шимтгэлийг гэрээнд заасан хөдөлмөрийн хөлс, орлогоос тооцож бүрэн төлүүлэх зохицуулалтыг тусгаснаар даатгуулагч өндөр наслах, хүүхэд төрүүлэх хөдөлмөрийн чадвараа түр болон удаан хугацаагаар алдах, нас барах зэрэг эрсдэл тохиолдох үед нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж авах эрх үүсэх зэрэг даатгуулагчид таатай, уян хатан үйлчилгээний нөхцөл бүрдэж байгаа юм. Тодруулбал өмнөх гэрээний нөхцлөөр

даатгуулагч 10 сарын 28-ны өдөр сайн дурын гэрээ байгуулсан бол тухайн өдрөөсөө тооцож шимтгэлээ төлдөг байсан бол нийгмийн даатгалд сайн дураар даатгуулсан тухай гэрээний загвар (НД №10)-ыг шинэчлэн боловсруулснаар 10-р сарын шимтгэлээ бүрэн төлөхөөр болж байгаа юм.

МАЛЧИН, ХУВИАРАА ХӨДӨЛМӨР ЭРХЛЭГЧИЙН ТЭТГЭВРИЙН ДААТГАЛЫН ШИМТГЭЛИЙГ НӨХӨН ТӨЛҮҮЛЭХ ХУУЛИЙН ХҮРЭЭНД СУДАЛГАА, ТООЦООЛОЛ ХИЙВ

Улсын Их Хурлын 2015 оны 53 дугаар тогтоолоор баталсан “Төрөөс тэтгэврийн шинэчлэлийн талаар баримтлах бодлого /2015-2030 он/, Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт тусгагдсан малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн нийгмийн даатгалын хамралтыг нэмэгдүүлэх ажлын хүрээнд Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд, Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын хамтарсан албан даалгаврын төслийг боловсрууллаа. “Малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх тухай” хуулийн төсөлтэй холбоотойгоор малчдын насны бүтэц, нийгмийн даатгалд хамрагдсан байдал, малчнаар шимтгэл төлж тэтгэвэр тогтоолгосон иргэдийн судалгаа зэргийг гарган, 1995-2017 он хүртэлх хугацаанд тэтгэврийн даатгалын шимтгэлийг 10 хувиар нөхөн төлүүлэхээр тооцож холбогдох судалгаа, тооцооллыг хийв.

ТЭТГЭВРИЙН ХҮҮГ БУУРУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР ТООЦООЛОЛ ХИЙЖ, АРИЛЖААНЫ БАНКУУДАЙ ХАМТРАН АЖИЛЛАЖ БАЙНА



Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдаас өгсөн чиглэлийн дагуу Эрүүл мэнд, нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2016 оны 10 дугаар 13-ны өдрийн А/30 тоот тушаалаар тэтгэврийн зээлийн хүүг бууруулах талаар санал боловсруулах ажлын хэсэг байгуулан ажиллаж байна. Нийгмийн даатгалын сангаас 2016 оны 09 дүгээр сарын байдлаар нийт 390708 тэтгэвэр авагч тэтгэвэр авч байна. Харин арилжааны банкуудаас хамгийн сүүлд авсан

мэдээнээс үзэхэд 216140 тэтгэвэр авагч 501.9 тэрбум төгрөгийн тэтгэврийн зээлтэй байна гэсэн дүн мэдээ гарсан байна. Ажлын хэсэг тэтгэвэр олголт, тэтгэвэр авагчдын зээлийн хүүгийн хэмжээ, зээл олгож байгаа нөхцөл, гарч болох эрсдэл, талуудаас тавигдах шаардлагуудын талаар нарийн судалгаа хийж арилжааны банкуудтай хамтран ажиллаж байна.

“НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ЧӨЛӨӨТ ҮЛДЭГДЭЛ, ХУРИМТЛАЛЫН САНГААС АРИЛЖААНЫ БАНКИНД МӨНГӨН ХАДГАЛАМЖ ХЭЛБЭРЭЭР БАЙРШУУЛАХ ЖУРАМ”-Д НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛНА

Монгол банкны бодлогын хүү нэмэгдсэнтэй холбогдуулан арилжааны банкуудад байршиж буй мөнгөн хадгаламжийн хүүг нэмэгдүүлэх судалгааны санал, тэтгэврийн зээлийн хүүг бууруулах, хадгаламж байршуулах арилжааны банкыг сонгох, хадгаламжийн эрсдэлийг бууруулах, нэг банкинд байршуулах хадгаламжийн хэмжээг хязгаарлах зорилгоор “Нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдэл, хуримтлалын сангаас арилжааны банкинд мөнгөн хадгаламж хэлбэрээр байршуулах журам”-д нэмэлт өөрчлөлт оруулах саналуудыг боловсруулан Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлд хүргүүлээд байна. Одоогийн байдлаар нийт есөн арилжааны банкинд 577 тэрбум төгрөгийг мөнгөн хадгаламж хэлбэрээр байршуулсан байна. Харин 57 тэрбум төгрөгийн Засгийн газрын үнэт цаас буюу бонд эзэмшиж байна. Тайлант хугацаанд нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлээс арилжааны банкинд харилцах данс, мөнгөн хадгаламж хэлбэрээр байршуулан, Засгийн газрын үнэт цаас худалдан авснаар мөнгөн хадгаламжийн хүүгийн орлого 37,9 тэрбум төгрөг, харилцах дансны хүүгийн орлого 5,6 тэрбум төгрөг, үнэт цаасны хүүгийн орлого 9,8 тэрбум төгрөгийг төвлөрсөн санд хүлээн авсан байна.

НИЙГМИЙН ДААТГАЛТАЙ ХОЛБООТОЙ ЭРХ ЗҮЙН БИЧИГ БАРИМТЫН ДАВХЦАЛ, ЗӨРЧЛИЙГ АРИЛГАНА

Нийгмийн даатгалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2017 оны төсвийн тухай зэрэг хуулиудын үзэл баримтлал, танилцуулга, холбогдох тооцоолол, төслийг салбарын яаманд хүргүүлээд байна. Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбоотой гарсан дүрэм, журам, заавар, зөвлөмжийн зөрчилтэй байдал, давхардал зэргийг цэгцлэх, шаардлагатай дүрэм, журмыг шинэчлэх, сайжруулах, програм хангамжийг боловсронгуй болгох чиглэлд анхааран ажиллаж байна.

74 ИРГЭНИЙ ХОЁР УЛСАД АЖИЛЛАСАН ЖИЛИЙГ БАТАЛГААЖУУЛАН ТООЦЛОО

Бүгд Найрамдах Монгол Ард Улс, Зөвлөлт Социалист Бүгд Найрамдах Холбоот Улсын хооронд байгуулсан “Нийгэм Хангамжийн салбарт хамтран ажиллах тухай” хэлэлцээрийн хэрэгжилтийн хүрээнд Монгол Улсаас Оросын Холбооны Улсад ажилласан хугацаагаа баталгаажуулахаар хүсэлт гаргасан иргэдийн хүсэлтийг ОХУ-ын Тэтгэврийн Фондод хүргүүлэх, ОХУ болон Украин улсын Тэтгэврийн Фондоос ирүүлсэн ажилласан жил баталгаажуулахыг хүссэн иргэдийн хүсэлтийг шийдвэрлэн хариу хүргэх ажлыг зохион байгууллаа. ОХУ-ын 58 иргэн, Украин улсын 10 иргэн, Монгол улсын 4 иргэн нийт 72 иргэний ажилласан жилийг баталгаажуулан тооцлоо.

СОЛОНГОСЫН ТАЛД ТӨЛӨГДСӨН БАЙСАН 38.8 САЯ ВОННЫГ ДААТГУУЛАГЧИД БУЦААН ОЛГОЛОО



Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Солонгос Улсын Засгийн газар хооронд байгуулсан “Нийгмийн хамгааллын тухай хэлэлцээр”-ийг хэрэгжүүлэн ажиллаж байна. Засгийн газрын 100 хоногийн тайлант хугацаанд БНСУ-ын Үндэсний тэтгэврийн албанаас шимтгэлээ буцаан авахаар хүсэлт

гаргасан 35 даатгуулагчийн нийт 43.9 вонны нэхэмжлэлийг хянаж 14 даатгуулагчид 38.8 сая вонны буцаан олголтыг олгоод байна. 21 даатгуулагчийн нэхэмжлэлийг шийдвэрлэхээр шалгаж байна. 2016 оны байдлаар 50 иргэний Солонгосын талд төлөгдсөн 67,5 сая вонны шимтгэлийг буцаан олгосон байна.

ЦАХИМ ҮЙЛЧИЛГЭЭГ ИДЭВХЖҮҮЛЭН ДААТГУУЛАГЧДАД ХҮЛЭЭГДЭЛГҮЙ ҮЙЛЧИЛЖ БАЙНА

Даатгуулагчдаа дараалалд зогсоож хүлээгдэл үүсгэхгүйн тулд цахим үйлчилгээг идэвхжүүлж байна. Тухайлбал тайлант хугацаанд нийгмийн даатгалын үйлчилгээний цахим машинаас нийт 134934 даатгуулагч хандаж, 26370 даатгуулагч дөрвөн төрлийн лавлагаа, мэдээлэл авсан байна. Нийгмийн даатгалын шимтгэлийн лавлагаа 25283 иргэн, нэрийн дансны лавлагаа 542 иргэн, тэтгэврийн эрх үүссэн эсэх лавлагаа 339 иргэн, ажил олгогчийн лавлагаа 206 ажил олгогч авчээ.



НИЙГМИЙН ДААТГАЛЫН ХАМРАЛТЫГ НЭМЭГДҮҮЛЭХ ЧИГЛЭЛД СУРГАЛТ, СУРТАЛЧИЛГАА ТОГТМОЛ ЗОХИОН БАЙГУУЛЖ БАЙНА



Иргэд даатгуулагч, ажил олгогчдод нийгмийн даатгалын багц хуулийг сурталчлах, мэдээлэх, мэргэжил арга зүйн удирдлагаар хангах, нийгмийн даатгалын хамралтыг нэмэгдүүлэх чиг үүргийн хүрээнд нийт 33 удаагийн сургалт, өдөрлөг зохион байгуулж 19959 даатгуулагч, иргэнд зөвлөгөө мэдээлэл өгч ажиллажээ.

Эрүүл мэндийн даатгалын хамралтыг нэмэгдүүлэхэд онцгойлон анхаарч Эрүүл мэндийн даатгалын тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн талаарх сургалтанд 32 их, дээд сургуулийн 13395 оюутан, суралцагчийг хамруулан мэдээллээр хангасан байна.

Мөн хувиараа хөдөлмөр эрхлэгчдийг даатгалд хамруулж болзошгүй нийгмийн эрсэдлээс хамгаалах зорилгоор Швейцарийн хөгжлийн агентлагийн “Тогтвортой бичил уурхай төсөл”-тэй хамтран гар аргаар олборлолт хийдэг иргэдийг хуулийн мэдээллээр байнга хангаж буй бөгөөд хамгийн сүүлд 15 аймаг, дүүргийн бичил уурхай бүхий сумдын нийгмийн даатгалын 60 байцаагчийг оролцуулсан “Бичил уурхай эрхлэгчдэд нийгмийн даатгалын үйлчилгээг хүргэх нь” сэдэвт сургалтыг 2016 оны 10 дугаар сарын 10-13-ны өдрүүдэд зохион байгууллаа. Зорилтот бүлэгт чиглэсэн сургалтыг зохион байгуулсны үр дүнд эрүүл мэнд, нийгмийн даатгалын хамралт тогтмол өсөж буй таатай статистик гарсан байна.

НИЙГМИЙН ДААТГАЛЫН ШИМТГЭЛИЙН АВЛАГЫГ БАРАГДУУЛАХ АЖЛЫГ ЭРЧИМЖҮҮЛЭВ

Нийгмийн даатгалын орлогын төлөвлөгөөг таслалгүй, нийгмийн даатгалын үйлчилгээг иргэд даатгуулагчдад саадгүй хүргэхийн тулд нийгмийн даатгалын сангийн орлогод эзлэх шимтгэлийн авлагын хэмжээг бууруулах нь аль ч цаг үед чухалаар тавигдаж ирсэн. Энэ хүрээнд нийгмийн даатгалын шимтгэлийн авлага барагдуулах ажлыг эрчимжүүлэн ажиллаж байна.



**373 аж ахуй нэгж
байгууллагийн харилцах**

Нийгмийн даатгалын шимтгэлийн өртэй үйл ажиллагаа нь хэвийн явагдаж байгаа 373 аж ахуйн нэгж, байгууллагад итгэл хүлээлгэж, үүссэн шимтгэлийн төлбөрийг тодорхой хуваарийн дагуу төлүүлэх хуваарь гарган баталгаажуулж, харилцах дансны зарлагын гүйлгээ хийх эрхийг нь нээж,

шүүхийн шатанд шилжүүлэх зэрэг үйл ажиллагааг түр хугацаагаар хойшлуулах арга хэмжээг авлаа. Улсын хэмжээнд зохион байгуулсан дээрх арга хэмжээний хүрээнд нийт 763 аж ахуй нэгж, байгууллагад улсын байцаагчийн албан шаардлага, мэдэгдэх хуудас хүргүүлж, баталсан хуваарийн дагуу шимтгэлийн өрөө төлөөгүй 284 байгууллагын харилцах дансны зарлагын гүйлгээг хааснаар нийтдээ 29,7 тэрбум гаруй төгрөгийн орлогыг нийгмийн даатгалын санд төвлөрүүлжээ.

ДОТООД ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ЦАХИМ МЭДЭЭЛЛИЙН САНТАЙ БОЛЛОО

Дотоодын хяналтаар 5 аймаг, 6 дүүргийн нийт 11 хэлтсийн үйл ажиллагааг шалган нийт 175,9 сая төгрөгийн төлбөр, зөрчил илрүүлснээс 101,6 сая төгрөгийг санд төлүүлсэн байна. 2010-2016 онуудад хийгдсэн шалгалтуудын мэдээллийг цахим санд бүртгэн, мэдээллийн сантай болсноор зөрчлийн шалтгаан нөхцлийг тогтоох бууруулахад бодит үр дүнтэй ажил боллоо.

ЭРҮҮЛ МЭНД НИЙГМИЙН ДААТГАЛЫН БАЙГУУЛЛАГУУДААР ДАМЖУУЛАН ДААТГУУЛАГЧИЙН СЭТГЭЛ ХАНАМЖИЙН СУДАЛГААГ АВЧ НЭГТГЭВ

“Бид даатгуулагчийнхаа итгэл найдвар сэтгэл ханамжаар үнэлэгдэх нийгмийн даатгалын үйлчилгээг хүргэнэ” гэсэн эрхэм зорилгоо бодит ажил болгохын тулд 21 аймаг 9 дүүргийн харъяа хэлтэс нэгжээрээ дамжуулан даатгуулагчийн сэтгэл ханамжийн судалгааг авлаа. Эрүүл мэнд нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагаа сайжирж байгаа буюу хэвийн байна гэж судалгаанд оролцогчдын 98 хувь нь хариулсан нь эрүүл мэнд, нийгмийн даатгалын байгууллагын үнэлэмж харьцангуй сайн байгааг илэрхийлж байгаа ч үйлчилгээний чанарыг сайжруулах чиглэлээр байцаагчдын үйлчилгээг сайжруулж, хуулийн өөрчлөлт болон бусад мэдээллийг шуурхай хүргэхэд анхаарах шаардлагатай болох нь ажиглагдсан юм. Тус судалгаагаар даатгуулагчдын сэтгэл ханамжийг тандаад зогсохгүй сургалт сурталчилгааны хэрэгцээг тодорхойлсноороо онцлог байсан бөгөөд цаашид цахимаар санал өгөх боломж бүрдүүлэх, судалгааны дүгнэлтэд тулгуурлан үйлчилгээний маркетингийг сайжруулахад анхааран ажиллаж байна.

1800-1289 ЛАВЛАХ УТАСНЫ ЭРГЭХ ХОЛБООГ САЙЖРУУЛЛАА



Нийгмийн даатгалын үйлчилгээний лавлах 1800-1289 утсанд 2016 онд нийт 24578 иргэн холбогдаж зөвлөгөө мэдээлэл авсан байна. Үйлчилгээний лавлах утсыг шинэчилж, эргэх холбоог сайжруулах ажлыг зохион байгуулж байна. Ингэснээр зөвхөн хуулийн мэдээлэл, мэргэшсэн зөвлөгөө, лавлагаа өгөөд зогсохгүй иргэдийн санал, гомдол, хүсэлтийг албан ёсоор бүртгэж, цааш

уламжлан холбогдох арга хэмжээг авч ажиллах нөхцөл бүрдэж байгаа юм. Мөн тус утасны операторын тоог нэмэгдүүлэн хүртээмжийг сайжруулж буйн дээр Эрүүл мэнд нийгмийн даатгалын байгууллагын Ахмадын хороотой хамтран ахмадуудаа ажлын байраар хангаж, олон жилийн ажлын туршлагатай мэргэшсэн зөвлөхийг ажиллуулах болсноороо онцлог юм.